



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 02 дугаар сарын 23

№ 01/66 ДУА-2018/93/СТА-ТШЗ Мандалговь хот

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Сайнцагаан сумын 4-р сургуулийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар тээвэр шатахууны зардлаас томилолтын унааны зардал болон замын зардлыг гаргасан 569,800.00 /Таван зуун жаран есөн мянга найман зуун/ төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/, Сангийн сайдын 2014 оны 55 тоот тушаалаар батлагдсан “Эдийн засгийн ангилал”-д /Тээвэр шатахуун-Байгууллагын өөрийн авто тээврийн хэрэгсэлд зарцуулах шатах төслох материал бусдын тээвэрээр гэрээ байгуулсны үндсэн дээр ажла үйлчилгээ гүйцэтгүүлсний хөлс зэрэгт гарсан зардлуудыг энэ ангилалд бүртгэнэ. Мөн тухайн байгууллага өөрийн болон бусдын тээвэрээр түлш бэлтгэхтэй холбогдон гарах бензин шатахууны зардал, тээврийн хөлсийг энэ зардалд хамруулна./ гэж заасныг зөрчсөн.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.3-д /Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар, батлагдсан хэмжээнээс хэтрүүлэн зарцуулж, Төсвийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчсөн/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Зардлыг зориулалтын дагуу зарцуулах;
2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Төрийн аудитын газарт 2018 оны 03 дугаар сарын 25-ны дотор албан ёсоор ирүүлэхийг Сайнцагаан сумын 4-р сургуулийн төсвийн шууд захирагч С.Одончимэг, нягтлан бодогч П.Мөнгөнцэцэг нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН<sup>1</sup>:

АУДИТОР Т.ОЮУН-ЭРДЭНЭ

ЗӨВШӨӨРСӨН:

ЗАХИРАЛ С.ОДОНЧИМЭГ

НЯГТЛАН БОДОГЧ П.МӨНГӨНЦЭЦЭГ

<sup>1</sup> Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.